



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/494

Булган сум

**«Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх»
тусгай зөвшөөрлийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл" олгох цэгийн нэрсийг 1 дүгээр хавсралтаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр солих цэгийн нэрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү Захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 07 сарын 19-ний өдрийн А/518 дугаар захирамжийн Г.Энхбулган захиралтай "Мөнхжин" дэлгүүр, мөн 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/358 дугаар захирамжийн "Их гүн хайрхан" ХХК-тай холбогдох заалтыг хүчингүйд тооцсугай.

3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумдын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

4. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Ганбаяр цагдаагийн дэд хурандаа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа), сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Д.ПҮРЭВ-ОЧИР

6324011192

12 дугаар сарын 04

Аймгийн Засаг даргын 2024 оны
ны/ний өдрийн 12 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Баяннуур	“Бат Өсөх Ирээдүй” ХХК	“Ирээдүй”	Хүнсний дэгүүр	С.Алтангэрэл
2	Булган	“Премиум нэксус” ХХК	“СУ конвينيенс”	Хүнсний дэлгүүр	А.Ганхуяг
3	Булган	“Мөнх Уул Алтай” ХХК	“Мөнжин”	Хүнсний дэлгүүр	Г.Энхбулган
4	Орхон	“МТБА” ХХК	“Элбэг Орхон”	Хүнсний дэлгүүр	Б.Түмэндэлгэр
5	Хутаг-Өндөр	“Баатарван тур” ХХК	“Жигүүр”	Баар	Д.Баттөр
6	Хутаг-Өндөр	“Аргал булаг” ХХК	“Бургил”	Баар	Б.Золжаргал
7	Тэшиг	“Намуун цэцээхэн” ХХК	“Намуун”	Караоке баар	Б.Нямхүү
8	Рашаант	“Дайчин хосын Өргөө” ХХК	“Оюу”	Хүнсний дэлгүүр	Я.Оюунгэрэл
9	Бүрэгхангай	“Бүрэг жинстийн хишиг” ХХК	“Жинст”	Хүнсний дэгүүр	М.Хишигбуян
10	Булган	“Булган маргад” ХХК	“Маргад”	Хүнсний дэлгүүр	Л.Диваасүрэн
	Нийт-10				



Аймгийн Засаг даргын 20... оны
 ... дугаар сарын ...-ны/ний өдрийн ... дугаар
 захирамжийн 2 дугаар хавсралт

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН НЭР СОЛИХ ЦЭГИЙН НЭРС**

д/д	Сумын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Үйлчилгээний төрөл	Оноосон нэр	Шинээр тусгай зөвшөөрөл эзэмших		Үйлчилгээний төрөл
		Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр			Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр	
1	Хишиг-Өндөр	"Их гүн хайрхан" ХХК	Г.Төмөрч өдөр	Хүнсний дэлгүүр	"Гүн хайрхан"	"Ган жаргалант нутаг"	Б.Батхуяг	"Жаргалант" Хүнсний дэлгүүр
	Нийт -1							